

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2021 оны 8 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 8 сарын 24-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Наймдугаар сард 243 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 13 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 110 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2021 оны 08 дугаар сарын байдлаар шинээр төрсөн -136, үүнээс эрэгтэй – 60, эмэгтэй-76, нас барсан-51 үүнээс эрэгтэй-21, эмэгтэй-30, цахим иргэний үнэмлэх /16 нас хүрсэн шинээр авсан/ - 33, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 173, сум, дүүргээс шилжин ирсэн-14, /том хүн 5, хүүхэд-9 / тус тус бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын ИТХ-ын ээлжит бус 5-р хуралдаан болж төсөвт тодотгол хийлээ. Үүнд Аймгийн санхүүгийн дэмжлэг 20,0 сая төгрөгөөр нэмэгдэж энэ нь Ковид 19 гарсан өр авлагыг барагдуулах чиглэлээр засаг даргын нөөцийг нэмэгдүүлсэн болно. Мөн оны эхний үлдэгдэлээс 64,0 сая төгрөгийг дутагдаж байгаа эх үүсвэрт хуваарилах, МАА-н татварыг 40,0 сая төгрөг орохоор баталж ОНХС-д ХАА-н нөөц бүрдүүлэх, хадлан тэжээл бэлтгэх, угаалгын ванн барих зэрэг ажлыг хийхээр төлөвлөв. ТЗШ-ийн байгууллагын сургууль 80,0 сая төгрөгөөр нэмэгдэж, цэцэрлэг 14,0 сая төгрөг /хүүхдийн хоолны зардал/ хасагдаж батлагдсан байна. Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст төсвийн тодотголын материалыг хүргүүлсэн болно.

Худалдан авах ажиллагааны талаар

Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт ирж шалгалтанд бэлдэх шаардлагтай барим материалыг гаргаж амжилттай шалгууллаа.

- Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийг зарлаж 35,0 сая төгрөгөөр Санаа мед трейд ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгоод гэрээг байгуулсан.
- Жавхлантын багт 1500 м ЦДАШ-ын тендерийг 2 удаа зарлаж нэгч компани ороогүй тул хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж тендерийг дахин зарлахаар шийдвэрлээд байна.
- ЭМТ-ын урсгал засвар УТХО-аар 35,0 сая төгрөгийн тендер зарлах зураг төсвийг хийлгүүлээд байна.

Төсвийн төслийн чиглэлээр:

2022 оны бүх төсөв байгууллагуудын төсвийн төсөл, 2023-2025 оны төсвийн төсөөлөлийг хийж аймгийн санхүү төрийн сан болон Боловсролын газар, ЭМ-ийн газарт хүлээлгэн өгч, ТЗШ байгууллагуудын тогтмол зардлын төсвийн төслийг хийж өгсөн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль хамгааллын чиглэлээр:

Ногоон байгууламжийн чиглэлээр:

Сумын жишиг хорооллын ногоон байгууламжийн хашааний эвдрэл гэмтэл засвар үйлчилгээ хийж дууслаа. Хашааг өндөрлөх ажилд зорилтод бүлгийн иргэдээс сонгон авч ажилуулсан. Ажлын хөлсийг “Ногоон төгөл” төсөлд хамруулан цалинжууллаа.

Сумын төвийн Баясгалант талбайн ногоон байгууламжийн хашаа эд хогшилын засварлах, будах, сэргээх ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.

Ан амьтаны чиглэлээр:

Монгол улсын Байгаль орчин Аялал жуулчлалын Яамнаас гаргасан 2021оны 08сарын 04ны өдрийн 03/3449 дүгээр тогтоол Катар улстай байгуулсан 202115 гэрээг үндэслэн Уулбаян сумын нутаг дэвсгэрээс идлэг шонхор шувуу барих хүсэлтийн дагуу гэрээ байгуулан ажилж. Иргэдийн санал хүсэлтийг үндэслэн хяналт шалгалт хийж. Засаг Даргатай хамтран акт үйлдлээ.

Бусад чиглэлээр:

Сумын иргэдийн төлөөлөгчдийн ээлжит бус 5 хуралдаанаар Хог хаягдлын хураамжийг шинэчлэн тогтоох тухай, Ногоон байгууламж нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг хамгаалах тухай журам батлах тухай, Сумын бэлчээр ашиглалтын журам гэсэн 3-н асуудал хэлэлцүүлж Ногоон байгууламж, Хог хаягдал дэмжигдэн холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. Мөн Зүүнбулагын хашаа эд хогшилыг цаашид хариуцах байгууллагыг хөдөө аж ахуйн тасаг хариуцуулах саналыг ИТХ-д хүргүүлсэн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Малын үржүүлэг, бүртгэл:

Сүхбаатар аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 1/100 тоот тогтоолын дагуу ноосны урамшуулалд хамрагдах хүсэлтээ ирүүлсэн 468 малчин өрхийн материалыг ехсел программд шивж, падааны дугаарын дагуу дараалалд оруулах ажлыг 2021 оны 07 дугаар сарын 24-с 8 дугаар сарын 15-ыг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Мөн 8 дугаар сарын 17, 18нд хүсэлт ирүүлсэн малчдын данс, регистрийг тулгалтыг Хаан банк болон Төрийн банктай хамтран хийсэн. Сүхбаатар аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 1/100 тогтоолын дагуу иргэдийн

ирүүлсэн баримт материалыг 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр урамшуулал хариуцсан Сүхбаатар аймгийн Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн У.Ариунбулагт хүлээлгэн өгсөн.

Ус цаг уурын мэргэжилтэн Ш.Сарангэрэлтэй хамтран бэлчээрийн ургамлын даац багтаамжийг тодорхойлох, үр дүнг үнэлэх ажлын хүрээнд олон улсад ашиглаж байгаа шугам цэгийн аргачлалаар сум бүрд тогтоосон ажиглалтын цэг дээр даац тодорхойлох ажлыг зохион байгуулж, өвөлжилт хаваржилтын нөхцөлд үнэлэлт, дүгнэлт гаргах ажлыг хийсэн. Уг ажлын хүрээнд Тэгш, Бага цагаан, Долоон хашаат, Ац болон Дэрсэн худаг гэсэн 5 цэгийн 10 шугамнаас бэлчээрийн даац тодорхойлох дээж авах ажлыг 2021 оны 08 дугаар сарын 09, 10-нд хийж гүйцэтгэсэн.

Хөдөө аж ахуйн программд ХАА7 буюу Аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн тариалсан нарийн ногоо болон хүнсний ногоог нэг бүрчлэн га-аар илэрхийлсэн мэдээг 2021 оны 07 дугаар сарын 27,28-нд шивж оруулсан.

Иргэдээс ирсэн хадланд гарах хүсэлтийг хүлээн авч 2021 оны 07 дугаар сарын 25-нд Сүхбаатар аймгийн Хөдөө аж ахуйн газрын бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Лхамдуламд хүргүүлсэн. Мөн хадлангийн техникийн судалгааг авч 2021 оны 07 сарын 29-нд хүргүүлсэн.

Засаг даргын тамгын газраас хийж буй Баясгалант талбайг сэргээн засварлаж, будах ажилд гар бие оролцсон. Мөн 2021 оны 07 дугаар сарын 30-нд жишиг хорооллын худгын ногоон байгууламж хамгаалах зорилгоор хашааг өндөрлөх, тор татах ажилд гар бие оролцсон.

Эрүүл мэндийн төв:

Үзлэгийн мэдээ 2021 оны 07 –р сарын 23 ны байдлаар

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1217
2	Амбулаторийн үзлэг	966
3	Идэвхтэй хяналт	49
4	Гэрийн эргэлт	83
5	Гэрийн дудлага	179
6	Алсын дуудлага	109
7	Артерийн даралт	560
8	Чихрийн шижин	692
9	Хөхний үзлэг	377
10	Эсийн шинжилгээ	58

11	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	202
12	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	1, 2-р тун 3243, Пейзер вакцин - 16-17 нас, жирэмсэн, архаг хуучтай-294 иргэн хамрагдаад байна.
13	Түргэвчилсэн тест	762
14	ПГУ шинжилгээ	256
15	Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа	0
16	Гэрийн ажиглалтад байгаа	0

Ерөнхий боловсролын сургууль :

- 2021-2022 оны хичээлийн жилд 75 хүүхдийн ортой, дотроо гал тогоо, халуун ус, ариун цэврийн байгууламж бүхий дотуур байр ашиглалтад орлоо.
- 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хичээл сургалт эхлэхтэй холбогддуулан бэлтгэл ажлыг хангаж байна.
- Мобиком корпорациаас санаачлан Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас хэрэгжүүлж буй “Ухаалаг боловсрол” төслийн судалгаанд 6-15 насны 25 сурагч хамрагдаж дараагийн шатны уралдаанд оролцох эрхийг авлаа.
- Эрүүл мэндийн үзлэгт 16 багш, ажилчид хамрагдлаа.
- 8 дугаар сарын 16-25 хооронд эцэг эхчүүд хүүхдийнхээ регистрийн дугаараар PARENTS.EDU.MN апп-аар 1 дүгээр ангид элсэн суралцах 6 настай хүүхдээ бүртгүүлэх ажил явагдлаа.
- БМДИ-ээс зохион байгуулсан “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” 2 өдрийн сургалтад сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан нар, физик, математикийн чиглэлээр явуулсан “Phet”, “Тооны машин”, “Geo Geobra” 6 өдрийн сургалтад багш Б.Оюунжаргал, “ЕБС-ийн сурагчдын бие даан суралцах ажлын дэвтэр боловсруулах арга зүй” сургалтад багш Ж.Мөнхсайхан, номын санчдад зориулсан “Сургуулийн номын санч АМЧБО үйл ажиллагааг зохион байгуулах арга аргачлал” сургалтад номын санч Д.Натарцэцэг, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа” сургалтад багш Н.Уранбилэг нар тус тус хамрагдсан.
- БМДИ-ээс зохион байгуулсан “ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах” цахим сургалтад 24 багш, удирдах ажилтан хамрагдлаа.

Хүүхдийн цэцэрлэг:

- Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгтээ бүх багш ажилчид 100% хамрагдсан.
- Байгууллагын бүх өрөө тасалгаа, гаднах ОО, тоглоомын талбайдаа “шавьжгүйтгэл, халдваргүйтгэл”-ийг хийлгэлээ.

- Байгууллагын гаднах зэрлэг өвсийг зулгааж цэвэрлэлээ.
- Бүлгүүдийг бүрэн камержуулсан.
- Багш ажилчид 8-р сарын 16-аас ажилдаа бүрэн орлоо.
- Багш, ажилчдад зориулсан “Багшийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 16 хүнийг хамрууллаа.
- БМДИ-ээс явуулсан “ 2021-2022 оны хичээлийн жилийн бэлтгэх ажил анхаарах асуудал” сэдэвт сургалтад эрхлэгч-1, багш-6, туслах багш-5 нийт 12 хүн хамрагдлаа.
- Өмнөх хичээлийн жилд сургалтад хамрагдаж байсан 4-5 настай хүүхдийн эцэг эхтэй холбогдон бүртгэж баталгаажууллаа.
- 08.19-20-ны өдрүүдэд цэцэрлэгт шинээр элсэх 4-5 настай хүүхдийн бүртгэлийг зохион байгуулж, бүртгэл 48%-тай байна.
- Байгууллагын гадаад болон дотоод орчны эрсдлийг тооцож хариу арга хэмжээ авч ажиллаж байна.
- Тарьсан модны ургалтыг багш, ажилчид тус бүрээр нь хүлээн авч тооцлоо. Нийт модны ургалт 82%-тай байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Иргэдээс ирүүлэх өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авч, шийдвэрлэх зорилготой тусгай дугаарын 98514040 дугаарыг ажиллуулж байгаа өргөдөл, гомдол хүлээн авч байна. Мөн “Уулбаян сумын Засаг дарын Тамгын газар” гэсэн хаягтай бөгөөд цахимаар өргөдөл, гомдол хүлээн авч байна. Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар “Гэрийн тусгаарлалт, ажиглалад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэг” байгуулан хэсгийн ахлагчаар хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдэд зөвлөмж, баталгаажилтын хуудас, хууль, дүрмийг бэлтгэн өгч, өдөр бүр ярьж биеийн байдлыг үзэж байна. 2021 оны 08 дугаар сарын 24-ны байдлаар гэрийн тусгаарлалт, ажиглалтад иргэн байхгүй байна.

2021 оны 08 дугаар сарын байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-4, танхайрах-1 тус тус зөрчил гарсан байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ